

**“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР” БОЛОН ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ПРОТОКОЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 03 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг хэлэлцлээ.

Төсөл санаачлагчдийн зүгээс хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төсөлд дараах өөрчлөлтүүдийг оруулжээ.

Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтад цогцолборыг удирдах, ашиглах үйл ажиллагаа явуулна гэсэн нь нисэх буудлыг бүхэлдээ удирдах гэсэн хоёрдмол утгыг илэрхийлж байсан тул хэлэлцээрийн өөрчлөлтийн нэмэлт протоколд энэ асуудлыг тодорхой тусгаж, “Талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын “Чингис хаан” олон улсын нисэх буудлын агаарын хөлгийг түлшээр цэнэглэх дэд бүтцийг удирдах болон ашиглах Хамтарсан компани байгуулна.” гэж өөрчлөлт оруулсан.

5 дугаар заалтад “Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоод зах зээлд газрын тосны бүтээгдэхүүнийг борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх асуудлыг хангана” гэж заасныг газрын тосны бүтээгдэхүүн гэж бүх төрлийн шатахууныг хамааруулсан утгатай заалт орсон тул тодруулах, хуульд нийцүүлэх зорилгоор “Монголын тал хамтарсан компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын дотоод зах зээлд агаарын хөлгийн түлш борлуулах үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн дагуу тогтоосон хязгаарлалтууд үйлчлэхгүй байх асуудлыг хангана.” гэж өөрчлөлт оруулсан.

7 дугаар зүйлийн 1 дүгээр догол хэсэгтэй давхацсан утгыг илэрхийлж байгаа тул хоёр талаас зөвшилцсөний үндсэн дээр 7 дугаар зүйлийн 2 дугаар догол мөрийг хассан.

Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн 2 дугаар догол хэсэгт Оросын талын арбитрын шүүх маргаан таслахаар тусгагдсан нь зохимжгүй тул гуравдагч орны арбитрын шүүхийг сонгох саналыг Монголын талаас гаргаж, хэлэлцээрийн явцад

Бүгд Найрамдах Беларусь Улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитрын шүүх байхаар өөрчлөлт оруулсан.

Хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн эхний догол мөрөнд Монгол Улс болон Оросын Холбооны Улсын хооронд үйлчилж буй ижил асуудал зохицуулсан бусад олон улсын хэлэлцээрээс давуу эрхтэй байна гэсэн заалт орсон нь олон улсын эрх зүйн акт, хэм хэмжээг үгүйсгэсэн, давж үйлчлэх утгатай Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй байсан тул Монголын талын саналаар хассан.

Мөн хэлэлцээрийн анхны хувилбарт 20 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх заалттай байсныг 15 жил болгож хугацааг богиносгосон өөрчлөлтүүдийг тус тус оруулсан байна.


Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хэлэлцээрт оруулж байгаа өөрчлөлттэй холбоотой ямар эерэг болон сөрөг үр дүн гарна гэж тооцож байгаа талаар мөн Оросын Холбооны Улстай манай улс газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгах гэрээ хэлэлцээр хийсний дараагаар Оросын Холбооны Улс дахин мэдэгдэл гаргасан нь манай улсад хэрхэн нөлөөлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хэлэлцээрт заасан хамтарсан компанийн үйл ажиллагааны талаар, цаашдаа авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хэдэн он гэхэд дэд бүтэц нь бий болж тогтвортой байдлаа бүрэн хангаж ажиллах талаар болон маргааныг Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотод байрлах Беларусын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитрын шүүхийн 2011 оны журмын дагуу хэлэлцүүлэхээр шийднэ гэж тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн 2 дугаар догол мөрийг хассан нь нарийвчилсан тодорхой заалтыг хэт ерөнхий болгож байгаа талаар, мөн энэхүү хэлэлцээр нь манай улсын зах зээл болон олон талт хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах тухай протоколын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу тусгаар тогтносон, бие даасан улс байхтай холбоотой асуудлууд дээр Монгол Улс зөв шийдвэр гаргаж байх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг шатахууны үнэ өртгийн талаар тус тус саналаа хэлсэн болно.

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг зөвшилцөхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Р.СЭДДОРЖ